

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

~~1.1.Цагдаагийн алба хаагчаас баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчийн нэр төрийг хамгаалахад энэ дүрмийн зорилго оршино.~~

Цагдаагийн алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, хяналт тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас сэргийлэх, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

~~1.2.Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа нь шуурхай, тасралтгүй байж, хуулиа дээдлэн, шударга ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ажил хэрэгч, сөөлч, цагдаагийн алба хаагчийн нэр төр, алдар хүндийг ямагт өргөж, өөрийгөө хөгжүүлэн, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхийг эрхэмлэнэ.~~

Энэ дүрмийн зорилт нь цагдаагийн албаны үнэт зүйл¹, алба хаагчийн ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ шаардлагыг тодорхойлж, түүнийг хангуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, журмыг тогтоож, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3.Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

1.4.Энэ дүрмийг алба хаагч үйл ажиллагаандаа мөрдлөг болгох бөгөөд байгууллагын нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх, хууль, цагдаагийн алба хаагчийн нэр төр, ёс зүйг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлнэ.

~~1.3-1.5.Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:~~

~~1.3-1.1.5.1."цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" гэж энэ дүрмээр тогтоосон ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг;~~

~~1.3-1.1.5.2."цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил" гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;~~

~~1.1.5.3."цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хариуцлага" гэж цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг;~~

~~1.3-2.1.5.4."ноцтой зөрчил" гэж Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд тус бүр төдөржөйлөн заасан, цагдаагийн албаны нэр хүндийг **хүндэд харшлах аливаа үйлдэл хийх**, гутааж, эд хөрөнгийн хохирол учруулах зэргээр эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхийг **сөргөөр нөлөөлөх**, үр дагаврыг санаатай буй бөлгөсөн бий болгох, энэ дүрэмд заасан зөрчлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй үед 2 буюу түүнээс дээш~~

¹ www.police.gov Цагдаагийн байгууллагын үнэт зүйл "Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг"

зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг.

~~1.4.Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай хөлбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй.~~

~~1.5-1.6.Цагдаагийн алба хаагч нь бусдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчинэ.~~

Хоёр. Ёс зүйн хэм хэмжээ

~~2.1.Хууль дээдлэх:~~

Цагдаагийн алба хаагч нь хууль дээдлэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

~~2.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хэм хэмжээний эрх зүйн акт, дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлах;~~

~~2.1.2.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг сахин мөрдөж;~~

~~2.1.3.албан үүргээ гүйцэтгэх явцдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг үл задруулах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, албан ёсны шийдвэр гараагүй аливаа асуудлын талаар байр суурь илэрхийлэхгүй байх, зөвшөөрөлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх.~~

~~2.1.2.төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;~~

~~2.1.3.Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журам, заавар, байгууллагын соёл, дэг журмыг чанд баримтлах;~~

~~2.1.4.төр, байгууллага, хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэхгүй байх;~~

~~2.1.5.төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албан мэдээ, мэдээлэл, баримт сэлт, мэдээллийн санг хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгод ашиглах, бусдад шилжүүлэхгүй байх;~~

~~2.1.6.хууль зөрчсөн, авлига авсан, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэн ашигласан аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;~~

~~2.1.7.албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, аливаа нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;~~

~~2.1.8.цагдаагийн алба хаагч нь хууль тогтоомжид зааснаас бусад ажил эрхлэхгүй байх;~~

~~2.1.9.удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, тушаалыг биелүүлэх, захирах, захирагдах ёсыг баримтлах;~~

~~2.1.10.цагдаагийн алба хаагч дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах.~~

~~2.2.Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх:~~

Цагдаагийн алба хаагч тэгш байдлыг хангах зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.2.1.ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, цагдаагийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

~~2.2.1.2.2.хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;~~

~~2.2.2.цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдын эрхэнд хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх;~~

~~2.2.3.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, хамтран ажиллаж байгаа алба хаагчтай адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх.~~

2.2.3.алба хаагч үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх;

2.2.4.бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлон харьцахгүй байх;

2.2.5.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хавчин гадуурхах, эрхшээлдээ оруулахгүй байх;

2.2.6.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хамтран ажиллаж байгаа алба хаагч, ажилтантай хүндэтгэлтэй, хүлээцтэй, адил тэгш харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.2.7.Цагдаагийн алба хаагч, үүргээ гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлдэг байх;

2.2.8 Цагдаагийн алба хаагчид зөвхөн зайлшгүй дохиолдолд, албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хэмжээнд хүч хэрэглэнэ;

~~2.3.Шударгаар ажиллаж, амьдрах:~~

2.3.Алба хаагч шударга ёсны зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

~~2.3.1.хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлэн ашигласан болон ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэрэхгүй байх, хамтран ажиллаж байгаа алба хаагчид энэ талаар хууль ёсны шаардлага тавих;~~

2.3.1.шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

~~2.3.2.цагдаагийн байгууллагын нэр төр, алдар хүндэд харшлах аливаа зөхисгүй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;~~

2.3.2.хууль, тогтоомжид заасны дагуу өөрийн өмчийн байдал, түүнд орсон өөрчлөлт, орлогын талаар хөрөнгө орлогын мэдүүлэгтээ үнэн зөв, бүрэн мэдүүлэх;

~~2.3.3.бусад байгууллага, хамтран ажиллаж байгаа алба хаагчийн,~~

байгууллага, хуулийн этгдээдийн үйл ажиллагаанд албаны ажилд хүндэтгэлтэй хандаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлөхгүй, бусдад зуучлахгүй байж, харьяаллын бус хэрэг маргаанд оролцохгүй байх;

2.3.4.авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлахгүй байх;

2.3.5.албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр төрд харшилж **харшлах** бөлөх болон өөрийн санхүү, эдийн засгийн аливаа хэлцэл, хөрөнгө оруулалт, эдийн засгийн бусад ашиг сонирхлоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх, зуучлахгүй байх;

2.3.6.албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа этгээдэд давуу байдал бий болгох, үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, далайлган сүрдүүлэх, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байх;

2.3.7.алба хаагчийн шалгаж байгаа мэдээ, мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх;

2.3.8.байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх.

цагдаагийн байгууллагын нэр төр, алдар хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

2.1.9.албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байх;

2.3.10.албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байна.

~~2.4.Ёс суртахуунтай байх:~~

2.4.Алба хаагч ёс суртахуунтай зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

~~2.4.1.өөрийн болон албаны нэр төрийг ариун байлгах, иргэдтэй соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах, үл тоох, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргахгүй байх;~~

байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх;

~~2.4.2.албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, ялгаварлан гадуурхах, эрхшээлдээ байлгах, басамжлан доромжлох, сүрдүүлэхгүй байх;~~

албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

~~2.4.3.байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх;~~

өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшингээ дээшлүүлэх нь насан

туршийн үйл явц гэж ухамсарлан ойлгож, бүхий л боломж, бололцоог ашиглан өөрийгөө хөгжүүлж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг эрмэлзэх бөгөөд дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлэх;

~~2.4.4.албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;~~

~~2.4.5.~~**2.4.4.**цагдаагийн алба хаагч нь ажлын байранд мөрийтэй, бооцоотой тоглоом, иргэний хувьд хуулиар хориглосон тоглоом тоглох, зохион байгуулахад оролцохгүй байх;

~~2.4.6.~~**2.4.5.**ажлын байранд, ажлын цагаар эсхүл албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон цагдаагийн дүрэмт хувцастай согтууруулах ундаа хэрэглэх, хуулиар хориглосон газарт утаат тамхи татахгүй байх;

~~2.4.7.~~**2.4.6.**олон нийтийн газар, авто зам, гудамж талбайд бие засах, эсхүл нус цэр, шүлс, тамхины иш, хог хаяхгүй байх;

~~2.4.8.~~**2.4.7.**согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

~~2.4.9.~~**2.4.8.**шалгаж байгаа өргөдөл, гомдол, хэрэг, маргааны оролцогчидтой хувийн харьцаанд орохгүй **харьцаа тогтоохгүй** байх;

~~2.4.10.~~**2.4.9.**гэр бүл, үр хүүхдэдээ хайр, халамжтай байж, нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх;

~~2.4.11.~~**2.4.10.**олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албаны мэдээ, мэдээлэл, цагдаагийн дүрэмт хувцастай зураг, санал, сэтгэгдэл оруулахгүй, ажлын цагаар хувийн асуудлаар цахим сүлжээнд орохгүй байх;

~~2.4.12.~~**2.4.11.**цагдаагийн дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй байх;

~~2.4.13.~~**2.4.12.**иргэдтэй маргалдах, хэл амаар доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, шивнэлдэх, инээлдэх, залхсан, эсвэл уцаарласан өнгөөр харьцах зэргээр зан харьцааны дутагдал гаргахыг цээрлэх;

~~2.4.14.~~**2.4.13.**алба хаагчидтай соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцах;

~~2.4.15.~~**2.4.14.**цагдаагийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харьцах.

2.5.Өөрийгөө хөгжүүлэх:

2.5.1.цагдаагийн алба хаагч нь өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшингээ дээшлүүлэх нь насан туршийн үйл явц гэж ухамсарлан ойлгож, бүхий л боломж, бололцоог ашиглан өөрийгөө хөгжүүлж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг эрмэлзэх бөгөөд дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Хариуцлага

3.1.Цагдаагийн алба хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан бол түүний эрхэлж байгаа **хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг** албан тушаал, цол, ажилласан жилийг үл харгалзан шалгаж шийдвэрлэнэ.

3.2.Ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан

Цагдаагийн албаны тухай хууль²-ийн 81.4 дэх хэсэгт **81 дүгээр зүйлд** заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан, дэс дараалан хэрэглэхгүйгээр оногдуулна.

3.3.Сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн **81 дүгээр зүйлийн** 81.6 дахь хэсэгт заасны дагуу ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй.

3.4.Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн **82 дугаар зүйлийн** 82.1.1-д заасны дагуу албанаас хална.

3.5.Ёс зүйн зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийг Цагдаагийн албаны тухай хуулийн **81 дүгээр зүйлийн** 81.9 дэх хэсэгт заасныг баримтлан, хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

3.6.Ёс зүй зөрчсөн алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг тусгай журмаар зохицуулна.

Дөрөв. Бусад

4.1.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар өдөр тутам хяналт тавьж ажиллана.

~~4.2.Цагдаагийн төв, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь энэхүү дүрмийг алба хаагчид танилцуулан гарын үсэг зуруулж, жилийн эцэст үр дүнгийн гэрээгээр үнэлэлт, дүгнэлт өгнө.~~

~~4.3.Ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг дараах байдлаар урамшуулж болно:~~

4.2.Ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгаа нь алба хаагчийг шагнаж, урамшуулах, өөр албан тушаалд дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал бууруулах үндэслэл болох бөгөөд ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн алба хаагчийг дараах байдлаар урамшуулж болно:

4.3.1.хамт олны өмнө сайшааж хувийн хэрэгт тэмдэглэх;

4.3.2.цалинг үр дүнгээр нэмэх /тэтгэмж, мөнгөн урамшуулал олгох/;

4.3.3.боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох;

4.3.4.цалинтай амралт, сувилалд хамруулах;

4.3.5.цагдаагийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох;

4.3.6.албан тушаал дэвшүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах.

---oOo---

² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №20